



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БӨМБӨГӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 10/05

Задгай

Сумын 2023 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.5.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 12/55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2023 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Байгууллага, орлогын нэр төрөл	төгрөг/ /мянган
1.1.	Сумын төсвийн татварын орлого	510,049.0
1.1.1.	ЦХТА орлого /Суутган-1/	154,400.0
1.1.2.	ҮХЭХ-ийн татвар	9,400.0
1.1.3.	Газрын төлбөр	140,000.0
1.1.4.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	15,000.0
1.1.5.	Галт зэвсгийн албан татвар	3,225.0
1.1.6.	Улсын тэмдэгтийн хураамж	15,000.0
1.1.7.	Газрын дуудлага худалдаа	4,800.0
1.1.8.	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	52,224.0
1.1.9.	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0
1.1.10.	Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр	
1.1.11.	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,500.0
1.1.12.	Малын тоо толгойн албан татвар	60,000.0
1.1.13.	Хадгаламжийн хүүгийн орлого	42,000.0
1.1.14.	ҮХХХ борлуулсны орлого	4,000.0
1.2.	Сумын төсвийн татварын бус орлого	40,000.0
1.2.2.	Торгуулийн орлого	40,000.0
	Нийт дүн	550,049.0

1120089

Хоёр. Сумын 2023 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

		/мянган төгрөг/
д/д	ТЭЗ, түүний харьяа байгууллага	ДҮН
2.1.	Засаг дарга	26,000.0
2.1.1.	Сумын Засаг даргын Тамгын газар	26,000.0
	Үүнээс: Төсвийн байгууллагын өөрийн орлого	1000.0
	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого	25,000.0

Гурав. Сумын 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

		/мянган төгрөг/
д/д	Төсвийн захирагч	ДҮН
3.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	131,480.9
	Урсгал зардал	131,480.9
	Хөрөнгийн зардал	
3.1.1.	Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	131,480.9
	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа /70105/	131,480.9
	Урсгал зардал, үүнээс:	131,480.9
3.2.	Засаг дарга	1,600,310.3
	Урсгал зардал	865,187.4
	Хөрөнгийн зардал	735,122.9
3.2.1.	Засаг даргын Тамгын газар	606,719.0
	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/	606,719.0
	Урсгал зардал, үүнээс:	606,719.0
	Соёл урлаг /71702/	26,089.0
3.2.2.	Соёлын төв	26,089.0
	Урсгал зардал, үүнээс:	26,089.0
3.2.3.	Ерөнхий боловсролын сургууль	111,655.3
	Ерөнхий боловсрол /71802/	111,655.3
	Урсгал зардал, үүнээс:	111,655.3
	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	
	ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	111,655.3
3.2.4.	Цэцэрлэг	40,253.0
	Сургуулийн өмнөх боловсрол /71801/	40,253.0
	Урсгал зардал, үүнээс:	40,253.0
	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	
	ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	40,253.0
3.2.5.	Эрүүл мэндийн төв	40,471.1
	Эмнэлгийн тусламж үйлчилгээ /71602/	40,471.1
	Урсгал зардал, үүнээс:	40,471.1
	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	

		ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	40,471.1
3.2.6.	Орон нутгийн хөгжлийн сан		735,122.9
	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт /70503/		735,122.9
	Хөрөнгийн зардал		735,122.9
		Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	735,122.9
3.2.7.	Сум хөгжүүлэх сан		40,000.0
	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх		40,000.0
	Урсгал зардал, үүнээс:		40,000.0
		Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих	40,000.0

Дөрөв. Сумын төсвөөс 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг зардлын хэмжээг 1,731,791.3 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Сумын төсвөөс 2023 оны төсвийн жилд төсвийн шууд захирагчдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

Зургаа. Сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,731,791.3 мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

- 6.1. Сумын татварын болон татварын бус орлого 550,049.0 мянган төгрөг;
- 6.2. Сумын төсөвт Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 244,619.4 мянган төгрөг;
- 6.3. Сумын төсөвт Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 380,248.9 мянган төгрөг;
- 6.6. Сумын төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянган төгрөг
- 6.7. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлого 25,000.0 мянган төгрөг
- 6.8. Сумын төсвийн урд оны үлдэгдэл 221,000.0 мянган төгрөг
- 6.9. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн урд оны үлдэгдэл 294,874.0 мянган төгрөг
- 6.10. Сум хөгжүүлэх сангийн урд оны үлдэгдэл 15,000.0 мянган төгрөг

Долоо. “Сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. “Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. “Сумын төсвийн байгууллагуудын төсвийн эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА



Г.МАГНАЙБАЯР